

БАТЛАВ.
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА А.ЭНХМАНЛАЙ

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН МОНИТОРИНГИЙН ЦАХИМ
СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 02 дугаар
сарын- ны өдөр

№

Улаанбаатар хот

| Д/д | Ажлын нэр, төрөл | Тайлбар |
|-----|---|---|
| 1. | Ажил гүйцэтгэх үндэслэл | <ul style="list-style-type: none">- Газрын тухай хууль;- ГЗБГЗЗГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.5.2.3 дахь заалт;- ГЗБГЗЗГ-ын 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө. |
| 2. | Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал | <p>Газрын мониторингийн цахим системийн хөгжүүлэлт хийж үйл ажиллагааг боловсронгуй болгох ба дараах асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">1. Өгөгдөл мэдээллийг зохион байгуулж цэгцлэх;2. Газрын төлөв байдал, чанарын мониторингийн цахим системийг egazar.gov.mn дээр харагдах бүтэц загварыг шинэчлэх;3. Дундын мэдээллийн сангаар дамжуулан бусад системүүдтэй холбож иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх;4. Газрын төлөв байдал, чанарын мониторингийн цахим системд бүртгэгдсэн өгөгдөл мэдээлэлд орон зайн дүн шинжилгээ хийх;5. Газрын доройтол, нөхөн сэргэлт, хохирлыг тооцож, үр дүнг зураглах; |
| 3. | Хамрах хүрээ | <ul style="list-style-type: none">- Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжилтнүүдэд зориулсан улсын хэмжээнд хийгдэх цахим системийн хөгжүүлэлт. |
| 4. | Ажил гүйцэтгэх хугацаа | <ul style="list-style-type: none">- Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 4 сарын хугацаанд. |
| 5. | Ажлын иж бүрдэл | <p>1. Өгөгдөл мэдээллийг зохион байгуулж цэгцлэх:</p> <ul style="list-style-type: none">- 2018 оноос хойш хийгдсэн захиалгат хянан баталгааны цэгүүдийг нэгдсэн форматын дагуу хүлээлгэн өгөх ба эдгээр цэгийн мэдээллүүдийг газрын мониторингийн цахим системд оруулж, мэдээллийн санг баяжуулах;- Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн санд үүссэн нийт өгөгдөл мэдээллийн харагдах байдлыг цэгцэлж, дахин зохион байгуулах;- Бэлчээрийн газрын фото мониторингийн мэдээллийн санг Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн сантай холбох; |

2. Газрын төлөв байдал, чанарын мониторингийн цахим системийг egazar.gov.mn дээр харагдах бүтэц загварыг шинэчлэх:

- Газрын төлөв байдал, чанарын мониторингийн цахим системийн давхарга хэсэг дэх фото мониторинг, бэлчээр, хянан баталгаа гэсэн давхаргуудыг нэгтгэх үндсэн давхарга үүсгэх /Газрын мониторинг/;
- Газрын төлөв байдал чанарын мониторингийн цахим системд байрлах бүх төрлийн цэгийн мэдээллийг ангилах;
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн эзэмшиж, ашиглаж буй газрын хянан баталгааны ажлын мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар хардаг болох;
- Нэгж талбарын мэдээлэл дээр хянан баталгааны мэдээлэл дэлгэрэнгүй харагддаг болох;
- Олон нийтэд харагдах хэсгийн загваруудыг бэлтгэх;
- Газар эзэмших, ашиглах гэрээний хавсралтад хянан баталгааны ажлын дүгнэлтийг холбох;

3. Дундын мэдээллийн сангаар дамжуулан бусад системүүдтэй холбож иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх:

- Газрын кадастрын мэдээллийн системтэй холбож хянан баталгааны ажлын үр дүн буюу дүгнэлт, сүлжээний зураг болон "SHAPE" файлыг давхарга байдлаар харуулж дүн шинжилгээ хийдэг болгох;
- Газар эзэмшигч, ашиглагчийн гэрээний хавсралтад хянан баталгааны ажлын дүгнэлтийг холбож гэрээний заалтад нэмж тусгах;
- Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн системтэй холбож, газар зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилттэй уялдуулах;
- Газрын биржийн мэдээллийн системтэй холбож дуудлага худалдаагаар олгогдож буй газрын байгаль, цаг уур, хөрс, ургамлын мэдээллийг дэлгэрэнгүй болгож иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх;
- Хот байгуулалтын кадастрын мэдээллийн системтэй холбож барилга байгууламж, ногоон байгууламж, инженерийн дэд бүтцийн талаарх мэдээ, мэдээллээр мэргэжлийн байгууллагууд болон иргэн, хуулийн этгээдэд үйлчлэх;
- Фото мониторингийн цэгийн мэдээллүүдийг холбож нэгтгэн ажлын үр дүнг иргэд, олон нийтэд мэдээллээр үйлчлэх;
- Ус, Цаг уур орчны шинжилгээний газрын хяналтын цэгийн мэдээллийг Egazar.gov.mn системээр дамжуулан холбох;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай Egazar.gov.mn системээр дамжуулан байнгын ажиглалтын цэгүүдийг ашиглах;

| | | |
|----|---------------------------------------|--|
| | | <ul style="list-style-type: none"> - Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтэц “Геопортал”-д холбож харилцан мэдээлэл солилцох боломжийг бий болгох; - Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрүүдээр хэрэгжиж байсан дата мэдээллийг ашиглах, хөгжүүлэх; - Их, дээд сургуулиудад хэрэглэгддэг дата мэдээллийг ашиглах; <p>4. Газрын төлөв байдал, чанарын мониторингийн цахим системд бүртгэгдсэн өгөгдөл мэдээлэлд орон зайн дүн шинжилгээ хийх:</p> <ul style="list-style-type: none"> - Газрын төлөв байдал, чанарын мониторингийн цахим системд бүртгэгдсэн мониторингийн өгөгдөл мэдээллүүдэд харьцуулсан дүн шинжилгээг хийх модулийг хөгжүүлэх; <p>5. Газрын доройтол, нөхөн сэргэлт, хохирлыг тооцож, үр дүнг зураглах:</p> <ul style="list-style-type: none"> - Газрын мониторингийн системд бүртгэгдсэн мониторингийн цэгийн мэдээллүүд болон элэгдэж, эвдэрсэн, бохирдсон газрын мэдээллийг үндэслэн газрын хохирлын хэмжээг тооцох модулийг хөгжүүлэх; <p>Дээрх нэмэлт хөгжүүлэлтийг веб систем болон цахим системд давхар хөгжүүлэлт хийж, иргэн, аж ахуйн нэгж байгууллага болон бүх шатны төрийн байгууллага, их дээд сургуулиудын оролцоог бүрэн хангах.</p> |
| 6. | Техникийн шаардлага | <ul style="list-style-type: none"> - Захиалагч байгууллагаас баталсан ажлын удирдамж болон ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баримтлах. - Газар зүйн мэдээллийн системийн нээлттэй эх үүсвэрийн програм хангамжийг ашиглах; - Системийг нээлттэй эх үүсвэрийн өгөгдлийн сангийн удирдлага бүхий орчинд бүрдүүлсэн байх; - Мэдээллийн чанар орон зайн мэдээллийн дэд бүтцийн өгөгдлийн стандарт шаардлагыг хангасан байх; - Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн системд агуулагдах үндсэн элементүүдэд үндэслэсэн байх, орон зайн өгөгдлийн стандарт шаардлагыг хангасан байх; - Хэрэглэгчийн болон удирдлагын түвшинд сургалт зохион байгуулж боловсон хүчнийг чадавхжуулсан байх; - Бусад мэдээллийн сантай мэдээлэл солилцох зарчмыг баримталж, системээс төрөл бүрийн үйлчилгээ гаргадаг байх; - Цаашид нэмэлт хөгжүүлэлт хийх боломжтой байх. |
| 7. | Ажлын хяналт, шалгалт | <ul style="list-style-type: none"> - Захиалагчийн хяналтыг Газар зохион байгуулалт, геодези зураг, зүйн газар гүйцэтгэнэ. |
| 8. | Баримтын төвд хүлээлгэн өгөх материал | <ul style="list-style-type: none"> - Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайланг тоон болон хэвлэмэл байдлаар 1 хувийг хүлээлгэн өгөх; - Мэдээллийн сан, програм хангамжийн эх код, програм хангамжийн баримт бичгийг тоон болон хэвлэмэл байдлаар 1 хувийг хүлээлгэн өгөх; - Техникийн болон системийн бичиг баримт 1 хувь; - Захиалагчийн техникийн хяналтын дүгнэлт, ажлын |

| | | |
|-----|------------------------------|---|
| | | гүйцэтгэлийг цаасан болон тоон хэлбэрээр бичиж тус бүр 3 хувийг актаар хүлээлгэн өгөх; |
| 9. | Захиалагч байгууллага | - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар |
| 10. | Гүйцэтгэгч байгууллага | - Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, нөхөн сэргээх чиглэлээр мэргэжлийн эрхтэй байгууллагаар удирдуулсан, орон зайн мэдээллийн системийн програм хангамжийн хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг туршлагатай, өмнө нь энэ төрлийн ижил төстэй ажил гүйцэтгэж байсан хуулийн этгээд байна. |
| 11. | Санхүүжилт, эх үүсвэр | - Улсын төсвийн хөрөнгө оруулалт 10 сая төгрөг |
| 12. | Даалгаварт тусгагдаагүй ажил | - Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэж болох ба үүнийг гэрээний тусгай нөхцөлөөр тодорхойлно. |

ХЯНАСАН:

ОРЛОГЧ ДАРГА

М.БУЯНДЭЛГЭР

ЗАХИРГАА, УДИРДЛАГА,
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА

Р.ГАНХУЯГ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.ЛУВСАН

СУУРЬ СУДАЛГАА, МОНИТОРИНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ДӨЛ

БОЛОВСРУУЛСАН:

СУУРЬ СУДАЛГАА, МОНИТОРИНГИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.МӨНХЦЭЦЭГ

СУУРЬ СУДАЛГАА, МОНИТОРИНГИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.АНХБАЯР

СУУРЬ СУДАЛГАА, МОНИТОРИНГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭРДЭНЭБАЯР